# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт/ | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ батлагдан гарсантай холбоотой Монгол улсын хууль, УИХ-н тогтоол, Засгийн газрын тогтоол болон эдгээртэй уялдан гарсан журам, зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар бүхий 201 шийдвэрийг байцаагч ажилтнуудад тухай бүр танилцуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Байгууллагын веб сайт, фейсбүүк пейж хуудасны нэрийг Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар болгон өөрчлөн шинэчлэж цаг үеийн мэдээ, мэдээлэл, постыг бэлтгэн тухай бүрт нь нийтлэн түгээн ажилласан. Газрын сошиал хуудсаар 98 постер мэдээлэл | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | | | бэлтгэн түгээсэн хандалтын тоо 5434. Сайн дурын даатгалтай холбоотой 1 лайв хүргэсэн | | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын хэмжээнд нийт 171 мэдээлэл оруулдаг. Үүнээс 164 мэдээллийг хугацаанд нь мэдүүлж, дараа оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор оруулах 7 мэдээллийг оруулаагүй буюу хугацаа нь болоогүй байна. Хугацаандаа мэдээллээгүй гэсэн зөрчил илрээгүй байгаа болно. | 2024.01.01 2024.12.05 | 100% |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг | Илэрсэн төлбөр зөрчлийн 72.6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | 1. НДЕГ-с өгсөн 2 чиглэлийн дагуу 5 байгууллагын санхүүгийн баримтад нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж байна. Шалгалтаар олон улсын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн нэгж, төлөөний газар болох "Глобал сивик шейринг", "СТСЕ" гэсэн 2 байгууллагад нийт 29 даатгуулагчтай холбогдолтой 18.4 сая төгрөгийн улсын байцаагчийн акт бичиж шийдвэрлэсэн байна. Нүүрс | 2024.01.01 2024.12.05 | 55.3% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | баргдуулж ажиллана. | | | тээврийн үйл ажиллагаа эрхлэгч 3 байгууллагад шалгалтын ажил үргэлжилж байгаа бөгөөд үүнээс "Хуажунвэиэ" ХХК-ний холбогдох албан тушаалтнууд олдохгүй байгаа ба тус компаний талаарх мэдээллийг ХХЕГ, Гадаадын иргэн харъяатын газар, СХД-н татвар зэрэг байгууллагууд руу албан тоот явуулан хайж байна. 40%<br>2. Газрын даргаар аж ахуйн нэгжийг шалгах 4, дотооддоо шинээр нэвтэрсэн SICOS системийн тэтгэвэр, тэтгэмжийн олголт, ажилгүйдлийн тэтгэмжийн олголтыг шалгах 2, нийт 6 удирдамж батлуулсан. | | |
| | | | | | Шалгалтаар 4 байгууллагын 17 хүнтэй холбогдолтой 13.2 сая төгрөгний улсын байцаагчийн акт бичсэнээс 2.3 сая төгрөгийн барагдуулалттай байна. 17,4%<br>3. Дотоодын хяналтаар Тэтгэвэр, ХЧТАТ, ЖАТ, Ажилгүйдлийн тэтгэмжид нийт 86 иргэнтэй холбоотой 57.1 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрсэнээс 43.7 сая төгрөгийг санд буцаан төлүүлж, 76.5 хувьтай ажилласан байна. | | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн | Хилийн цэргийн 0151-р ангид илэрсэн 4 иргэнтэй холбоотой 3 төлбөр зөрчлын дүн 4907644 төгрөгийг бүрэн барагдуулсан. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон ХШГ-т тайлагнах, Илэрсэн зөрчил, дутагдлын 70 аас доошгүй хувийг барагдуулсан байх | сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Цаашид 0151-р ангийн хугацаат цэргийн алба хаагчийн шимтгэл төлөлтийг НД7, 8 тайлантай тулгах ажлыг хийхээр төлөвлөж байгаа болно. | | |
| 3.2.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнг эхний хагас жилээр тайлагнаж илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан шалгаж , шийдвэрлэх | Шалгалтыг Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө", Салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/08 дугаартай удирдамжид дурдсан асуудлын хүрээнд СБД, СХД, ЧД, БЗД БГД-үүдийн НДГ-ын ҮОМШӨС-ийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, ҮОМШӨС-аас тэтгэвэр авч байгаа 1090 иргэний мэдээллийг "Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан "(http://10.9.11.2:808/ndlav/Default.aspx), "Тэтгэврийн программ", тэтгэврийн хувийн хэрэгтэй тулган, 100 иргэнтэй уулзаж тайлбар тэмдэглэл хөтөлж хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар: БГД-ийн НДГ-ын 3 тэтгэвэр авагчийн 29,9 сая төгрөг, БЗД-ийн НДГ-ын 3 тэтгэвэр авагчийн 71,2 сая төгрөгийн акт үйлдэгдэж 5,8 сая төгрөг нь барагдсан. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

4

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | СХД-ийн НДГ-ын 5 тэтгэвэр авагчийн 4,8 сая төгрөгийн акт үйлдэгдэж 100% барагдуулсан. СБД-ийн НДГ-ын 1 тэтгэвэр авагчид 1,5 сая төгрөгийн акт үйлдэгдэж 100% барагдуулсан. Нийтдээ 107,5 сая төгрөгийн акт үйлдэгдсэнээс 11,3% буюу 12,2 сая төгрөгийг барагдуулсан байна. | | |
| 3.2.4 | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.2, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 6.2, 7.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөт шалгалтын жагсаалтыг үндэслэн Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан 13-07/04, 13-07/05, 13-07/10 тоот удирдамжуудын хүрээнд ХНХСайдын 2024.03.04-ний өдрийн А/42 тушаалын дөрөвдүгээр хавсралт 07.3.1 кодтой "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар эрсдлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх талаар мэргэжил арга зүйгээр хангаж батлагдсан 30 аж ахуй нэгжид хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. | | |
| 3.2.5 | Соёл, урлагийн байгууллагуудад хөдөлмөрийн харилцаа, аюулгүй байдал нийгмийн хамгааллын асуудлаар урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх (Нийслэл, Баян-Өлгий, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Дорнод, Ховд, Увс, Баянхонгор) | Зөрчил арилгуулалтын хувь | | Хэрэгжилт 50% | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр баталсан 05-00-00-001/04, 13-07/13 тоот удирдамжийн хүрээнд Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Хүүхэд залуучуудын театрт ХНХСайдын 2024.03.04-ний өдрийн А/42 тушаалын дөрөвдүгээр хавсралт 07.3.1 кодтой "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийхэд бага эрсдэлтэйгээр үнэлэгдсэн. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |
| 3.2.6 | Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | Акт, Албан шаардлагын биелэлт (тоо, хувь) Зөрчил арилгалт (хувь) | 2023 онд төлөвлөгөөт Шалгалтаар илэрсэн зөрчилд 946 заалт бүхий улсын байцаагчийн 193 албан шаардлага үйлдэж, 600 заалт биелэгдэж 63 хувьд хүрсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 145 заалт бүхий улсын байцаагчийн 58 | Албан шаардлагаар өгсөн үүрэг, даалгаварын биелэлтийг дүгнэж, тайлагнах | МУ-ын ЗГ-ын 2023.03.01-ний өдрийн "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 79 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх" удирдамжийн хүрээнд нийгмийн халамжийн сан болон нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон давхардуулан авч буй эсэхэд хяналт шалгалт хийж тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон өндөр насны тэтгэврийг давхардуулан олгосон нэр бүхий 6 иргэний давхардсан хугацааны 27.9 сая | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | албан шаардлагыг хүргүүлсэн ба 76 заалт 52 хувьтай байна. Мөн 1757 иргэнтэй холбоотой 1,145.7 сая төгрөгийг Санд нөхөн төвлөрүүлэх, 166 иргэнтэй холбоотой 27.2 сая төгрөгийг иргэн даатгуулагчид олгуулах нөхөн төлбөрийн нийт 211 заалт бүхий 83 акт тогтоож, нөхөн төлбөрийн биелэлт 15 хувьтай байна. | | төгрөгийн актаас 8,3 сая төгрөгийн актыг барагдуулсан байна.<br>"Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо" ГҮТББ-ын 74,7 сая төгрөгийн тусгай хэрэгсэлийг олгоогүй зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн.<br>Протез ортепед тусгай хэрэгсэл , амралт сувилал бусад үйл ажиллагаа эрхэлдэг 14 аж ахуй нэгжид 28,550,0 мян. төгрөгийн актаас 26,740,0 мян. төгрөгийг барагдуулсан /93,7%/.<br>СХДХХҮХ- 35,373,8 мян. төгрөгийн актаас 29,781,8 мян.төгрөг /84,2%/ ЧДХХҮХ-8,117,6 мян.төгрөгийн актаас 5,337,6 мян.төгрөг /65,8%/<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023.08.24-ны өдрийн 07/22 тоот удирдамжийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтийн гүйцэтгэлийн хяналт шалгалтаар СХДХХҮХ-т 39,885,0 мян.төгрөгийн акт-аас 37,985,0 мян. төгрөг /95,2%/ барагдуулсан. ЧДХХҮХ-ийн 47,545,0 мян.төгрөгийн актаас 32,300,0 мян.төгрөг /68%/ барагдуулалттай байна.<br>Нийт 204,266,3 мян. төгрөгийн акт үйлдсэнээс 151.429.9 мян.төгрөг /74,1%/-ийн актыг барагдуулан ажилласан байна. | | |
| 3.2.7. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган | Дотоодын хяналт шалгалт болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, хөндлөнгийн хяналт | | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар | Дотоодын хяналт шалгалт болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 2023 оны жилийн эцсийн | 2024.01.01<br>2024.12.05 | 68.1% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 20, 11 дугаар сарын 20-ны өдрийн дотор ХШГ-т хүргүүлнэ. | | хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулах | үлдэгдэл тэтгаврийн даатгалын 196,3 сая төгрөгөөс 92.5 сая, ажилгүйдлийн даатгалын 36.8 сая төгрөгөөс 0.1 сая, тэтгэмжийн даатгалын 5.4 сая төгрөгөөс 0.1 сая төгрөг буюу нийт 238.5 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 92.7 сая төгрөгийн барагдуулсан байна. 2024 онд 188.0 сая төгрөгийн төлбөр зөрчил нэмэгдэж бүртгэгдсэнээс 169.2 сая төгрөгийг барагдуулж тайлант хугацаанд нийтдээ 384.3 төгрөгийн төлбөр зөрчлөөс 261.9 төгрөгийг барагдуулж 68.1 хувьтай ажилласан байна. | | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар, шийдвэрийн талаар 201 ирсэн бичгийг холбогдох албан хаагчдад танилцуулан, цаг хугацаанд нь шийдвэрлэж, үүрэг даалгаврын биелэлтийг хүргүүлж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Мөн Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын дэлгэрэнгүй тайлан, тоон мэдээг 3 удаа НДЕГ-т тайлагнан хүргүүлсэн. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | | | | |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Тайлант хугацаанд Тус газарт хандан ирүүлсэн Нийт өргөдөл гомдол – 567,<br><br>Үүнээс Нийслэлийн цахим 11-11 төвөөр – 410, ННЗБ бүртгэсэн 134, 1800-1200 дугаарын оператор 10, E-Service 3, Дижитал сити 1, НҮНТ 8, НМХГ 1 тус тус өргөдөл гоидол ирсэн байна.<br><br>Үүнийг төрлөөр нь ангилбал:<br><br>Хүсэлт 156, гомдол 408, санал 1, талархал 2 ирсэн бөгөөд ажлын 5-7 хоногт 100% шийдвэрлэн ажилласан байна.<br><br>2024 оны хагас жилийн байдлаар тус газарт хандан ирүүлсэн Нийт албан бичгүүд– **1569**.<br><br>Үүнийг төрлөөр нь ангилбал:<br><br>Цаасаар – 1210,<br><br>Цахим программаар–359,<br><br>Шийдвэрлэсэн байдлаар ангилбал:<br><br>Шийдвэрлэсэн – 1538<br><br>Судлагдаж байгаа - 31<br><br>Үүнээс Хариутай бичиг 106, хугацаа сунгуулж судалж байгаа 1 албан бичиг байгаа бөгөөд нийт | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан бичгийг ажлын 3-14 хоногийн дотор шийдвэрлэн, хариуг хүргүүлэн ажилласан байна. | | |
| 4.1.3. | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | Нийгмийн даатгалын газар дотооддоо болон газар хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Нийгмийн даатгалын архивын үйлчилгээг иргэд даатгуулагчдад хөнгөн шуурхай үзүүлэх зорилгоор шимтгэл төлөлтийн лавлагааг цахим болгосонтой холбогдуулан тайлант хугацаанд бусад аймаг дүүрэг рүү 547 хүсэлт илгээснээс 533 хариу ирсэн ба бусад аймаг дүүргээс 525 хүсэлтийг хүлээн авч 519 хариуг хүргүүлсэн байна. Өөрийн биеэр ирж үйлчилгээ авсан 948 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.<br>Цахим мэдээллийн архив буюу QR код бүхий нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг 3336 иргэнд гарган өгсөн байна. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |
| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | ✓НДЕГ-ын даргын 2024 оны А/52 дугаар тушаалаар тус газрын орон тоог 64 орон тоотойгоор 5 хэлтэс, 1 тасагтай байхаар бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн баталсан.<br>2024 оны IV улирлын байдлаар 64 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:<br>• Удирдах албан тушаалтан 7<br>• Гүйцэтгэх албан тушаалтан 51<br>• Туслах 6 ажилтан байна.<br><br>Хүний нөөцийн өөрчлөлт, гүйцэтгэлийн мэдээ тайланг сар бүр | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацаанд нь НДЕГ-т хүргүүлж байна. | | |
| 4.1.5. | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | - Дотоод аудитор бэлтгэх сургалтад 6 албан хаагчыг хамруулсан,<br>- Албан хаагчдыг идэвхжүүлэх зорилгоор өглөөний уулзалтыг 2024.02.23-нд газар болон баянхошуу хэлтсийн бүх албан хаагчдыг хамруулсан.<br>- Спорт явган аялалыг 2024.05.11 нд зохион байгуулсан 58 албан хаагч оролцсон.<br>- Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ийн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Амарбаясгалан 2023 оны 05 сарын 04-ний өдөр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ойлголт болон төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлага сэдэвт сургалтад хамрагдсан.2024 оны 08.29 нд-ний өдөр 10 албан хаагчид ажилласан.<br>- Ёс зүйн дэд хорооноос сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг "Ёс зүйн академи"-ийн ерөнхийлөгч, Олон улсын хуульч (Ph.D) Ж.Оймандах төрийн албанд ёс зүйн тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээллэх, нийгэм дэх зөрэг, зөв хандлагыг дэмжих зорилготой. Нийт 37 албан хаагчид хамрагдсан. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Өөрийгөө хайрлая сэдэвт сургалтанд 47 албан хаагчдаа хамруулсан. Ажлын байрыг тогтвортой байлгах, ажлын байрны стресс сэтгэлзүйн асуудлыг шийдвэрлэх зорилготой | | |
| 4.1.6. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах. | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | 2024 оны нийгмийн баталгаа хангах хөтөлбөрт:<br>➢ Хүний нөөцийн хөгжлийн хүрээнд /4 зорилт, 9 арга хэмжээ/<br>➢ нийгмийн баталгааг хангах хүрээнд /4 зорилт, 9 арга хэмжээ/ нийт 8 зорилт, 18 арга хэмжээг тусгасан.<br>***Хэрэгжилт:***<br>1. 43 албан хаагч "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г газар, нэгжийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолттой уялдуулан боловсруулан, нэгжийн даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>2. Төрийн үйлчилгээний 28 (давхардсан тоогоор) албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.<br>3. Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагч ажлаас чөлөөлөгдөхгүйгээр хамрагдаж байгаа бөгөөд суралцсан хугацаанд ажлаа цалгардуулахгүй зохицуулсан тохиолдолд албан тушаалын цалин хөлсийг олгож, сурах боломжоор хангаж, дэмжлэг үзүүлж байна. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. 10 албан хаагчдад зэрэг дэв олгуулах болон ахиулах саналыг хүргүүлж, тэдэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар зэрэг дэвийг олгосон. Мөн шалгуур үзүүлэлт хангасан Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн эрхтэй 6 албан хаагчид "*Тэргүүлэх мэргэшлийн зэрэг*"-ийг, 10 албан хаагчид "*Зөвлөх мэргэшлийн зэрэг*"-*ийг* Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын тушаалаар олгосон.<br>5. Нийт хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд албан хаагчдыг үзлэг оношлогоонд 90% хамрууллаа.<br>6. НДЕГ-с зохион байгуулсан "Ул мөргүй аялагчид" аянд хамт олноороо оролцлоо.<br>7. Ажилтан албан хаагчдын ажиллах орчныг сайжруулснаар иргэд даатгуулагчдад тав тухтай үйлчлэх боломжийг нэмэгдүүллээ. Архивын өрөөнд архивын хадгаламжийн санд баримт хүлээн авах, сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалтад шаардагдах чийгшил, температур хэмжигч багажийг суурьлуулан, агааржуулагчийг байршуулсан нь баримт бичгийн хадгалалт хамгаалалтанд чухал нөлөө үзүүлэх юм.<br>8. Хоол, унааны зардалд нийтдээ 221,2 сая төгрөг олгосон. Мөн 3 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилтанд буяны ажилд оролцох чөлөөг ажлын 5 хүртэл өдрөөр тооцож цалинтай чөлөө олгож, нийтдээ 600.000 төгрөгийн, 1 ажилтанд шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулж 10 хоногийн чөлөөг олгож, 725910 төгрөгийн мөнгөн олговор, 1 ажилтанд 900000 төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус үзүүлээд байна. | | |
| 4.1.7. | Газрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | 1.Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Б.Сүрэнжав "Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 03-ний өдөр зохион байгуулсан.<br>Авлигаас ангид байж, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс зайлсхийх, тийм сэтгэгдэл төрүүлэхүйц харилцаа, хандлага гаргахгүй байхад онцгой анхаарч ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажиллалаа.<br>2."Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр комиссар Р.Төрбулаг, "Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт" сэдвээр комиссар М.Жамъяачойжил нар цахимаар (Zoom )сургалт зохион | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

14

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулав. 2024.10.18-ний өдөр сургалтад 19 албан хаагч оролцов.<br><br>3.Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2024 оны 11 дүгээр сарыг **"Ёс-той Зүй-тэй"** нөлөөллийн аян өрнүүлэхээр тогтсон. Аяны зорилго нь Төрийн албанд ёс зүйн тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээллэх, нийгэм дэх зөрэг, зөв хандлагыг дэмжих зорилготой юм. Энэхүү аянд нэгдэж, тус газрын Ёс зүйн дэд хорооноос сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг "Ёс зүйн академи"-ийн өрөнхийлөгч, Олон улсын хуульч (Ph.D) Ж.Оймандах "Байгууллагын ёс зүйн менежмент" сэдвээр удирдан явуулж, тус газрын албан хаагчид хамрагдав.<br><br>2024.11.14-ний өдөр сургалтад оролцогчийн тоо 48<br><br>4.Албан хаагчдад авлигын эсрэг гарын авлагыг тараан, бүх давхарын мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг байршуулж ажиллаж байна. | | |
| 4.1.8. | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг | Харилцаа хандлага сэдэвт сургалтыг СХД-ийн Насан туршийн боловсролын сургалтын төвийн багш Т.Хишигбуянтай 01 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

15

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | харилцах журам" батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | | сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Чанарын менежментийн тогтолцоонд ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016 ) стандартын дагуу аудитыг ISO 19011:2018 (MNS ISO 19011:2020) стандартад заасан аргачлалын дагуу хийх зарчим, арга зүйг эзэмшүүлэх зорилготой G2G сургалтын төв -ийн "ДОТООД АУДИТ"-ын М1, М3 сургалтад тус байгууллагын 6 албан хаагч амжилттай хамрагдаж гэрчилгээ гардан авсан.<br>2024.01.26-ны өдөр СХД-НДГ-ын үйл ажиллагаа ISO 9001:2015 стандартын шаардлагыг хир хэмжээнд хангаж байгаад аудит хийж дүгнэлт гаргасан. Аудитын явцад 0 үл тохирол илэрсэн.<br>Аудитын баг нь аудитын үр дүнгээр нийт 25 үзүүлэлтээс дараах 7 сайжруулах буюу стандарт, журмаар тогтоосон шаардлага биелэгдсэн боловч илүү боловсронгуй болгох шаардлагатай саналыг гаргасан. Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газрын чанарын менежментийн тогтолцоо нь ISO 9001:2015 стандартын шаардлагыг хангаж байна гэж дүгнэгдсэн байна. | | |
| 4.1.9. | Газрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах | Газрын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулах | | Газрын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг | 1.Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Б.Сүрэнжав "Авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг 2024 оны 04 дүгээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | сарын 03-ний өдөр зохион байгуулсан.<br><br>Авлигаас ангид байж, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс зайлсхийх, тийм сэтгэгдэл төрүүлэхүйц харилцаа, хандлага гаргахгүй байхад онцгой анхаарч ажиллаж байна.<br><br>Тайлант хугацаанд ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажиллалаа.<br><br>2."Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр комиссар Р.Төрбулаг, "Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт" сэдвээр комиссар М.Жамъяачойжил нар цахимаар (Zoom )сургалт зохион байгуулав. 2024.10.18-ний өдөр сургалтад 19 албан хаагч оролцов.<br><br>3.Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2024 оны 11 дүгээр сарыг **"Ёс-той Зүй-тэй"** нөлөөллийн аян өрнүүлэхээр тогтсон. Аяны зорилго нь Төрийн албанд ёс зүйн тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээллэх, нийгэм дэх зөрөг, зөв хандлагыг дэмжих зорилготой юм. Энэхүү аянд нэгдэж, тус газрын Ёс зүйн дэд хорооноос сургалт зохион байгуулсан бөгөөд сургалтыг "Ёс | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зүйн академи"-ийн ерөнхийлөгч, Олон улсын хуульч (Ph.D) Ж.Оймандах "Байгууллагын ёс зүйн менежмент" сэдвээр удирдан явуулж, тус газрын албан хаагчид хамрагдав.<br>2024.11.14-ний өдөр сургалтад оролцогчийн тоо 48<br>4.Албан хаагчдад авлигын эсрэг гарын авлагыг тараан, бүх давхарын мэдээллийн самбарт холбогдох мэдээллийг байршуулж ажиллаж байна. | | |
| 4.1.10. | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж хэвших | Хуулийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах | Хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. | Хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлт болон ажил албан тушаал өөрчлөгдөх үед хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр гаргаж хэвшсэн байна. | Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд буюу 02 дугаар сарын 15-ны дотор гаргах үүргийн дагуу бүх албан хаагчид хугацаандаа гарган өгсөн байна. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |
| 4.1.11. | Байгууллагын архивын баримтыг холбогдох хуулийн дагуу хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах | Холбогдох хуулиудыг мөрдөж ажиллах. | ..... баримтыг хүлээлгэн өгсөн. | Хөтлөх хэргийн жагсаалтад бүртгэлтэй архивын баримтыг стандартын дагуу баримтжуулж, хүлээлгэн өгсөн байна. | Хөтлөх хэргийн жагсаалтад бүртгэлтэй архивын баримтыг стандартын дагуу баримтжуулж,<br>-Зөрчлийн хэргийн материал /хялбаршуулсан/ - 4ш<br>-Зөрчлийн хэргийн материал /татгалзсан/ - 3ш<br>-Улсын байцаагчийн акт – 4ш<br>-Гомдлын шаардлагын зөвлөлийн материал – 3ш | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |

18

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Удирдамжтай шалгалтын материал – 4ш<br>-Малчны зөвлөлийн хурлын тэмдэглэл – 1ш<br>Нийт 19 нэгж архивын баримтыг хүлээлгэн өгсөн байна. | | |
| 4.1.12. | Төрийн албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөх, баяжилтыг тухай бүр шинэчлэх | Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг хэрэгжилтийг хангах | Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу хувийн хэргийн баяжилт хийсэн. | Төрийн албан хаагчийн анкетыг шинэчилж, хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийсэн байна. | Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу бүх албан хаагчид өөрсдийн хувийн хэргийн баяжилтыг хийж ажилласан байна. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 39 удаагийн сургалтад 809 /давхардсан тоогоор/ албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ. | Жилийн эцсийн байдлаар албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхим болон цахим нийт 17 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 115 албан хаагч сургалтад хамрагдсан.<br>• Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн танилцуулга сургалт<br>• Албан хэрэг хөтлөлтийн онол арга зүй сургалт<br>• Байгууллагын ёс зүйн менежмент<br>Өөрийгөө хайрлая гэх мэт сургалтуудыг албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой ажлийн бүтээмжийг сайжруулахаар явуулсан болно. | 2024.01.01<br>2024.12.05 | 100% |